



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 01 өдөр

Дугаар A/365

Сүхбаатар сум

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.3 дахь зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 100, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг угтаж, ардын хувьсгалын түүхийн дурсгалт, аялал жуулчлалын болон байгалийн үзэсгэлэнт газрууд, түүхэн олдворуудын талаарх мэдээлэл, Сэлэнгэ аймгийн ололт, амжилт, бахархалт зүйлсийг багтаасан “Зурагт цомог”-ийг хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Ө.Сувдаа

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Д.Лувсандагва

-Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Хишигням

-Төрийн архивын тасгийн дарга

Л.Бямбаа

-Аймгийн нэгдсэн музейн эрхлэгч

Д.Одонтунгалаг

-Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн

Т.Түмэнбаяр

-Гэрэл зурагчин /тохиролцсоноор/

Б.Батдорж

-Гэрэл зурагчин /тохиролцсоноор/

2. “Зурагт цомог”-т Дархан-Уул аймаг дахь ОХУ-ын консулын газрын санал хүсэлтийг тусган, хамтарч чанарын өндөр түшинд боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 01-ний дотор нийтийн хүртээл болгохыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ